



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар Б/32

Хэрлэн сум

А.Мөнхбайгальд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 65 дугаар зүйлийн 65.1.3, 65.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөн туслах ажлын дүнгээр “Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх” аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр албан даалгаврыг хангалтгүй биелүүлж, сумын хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаагүй тул Норовлин сумын Засаг дарга А.Мөнхбайгальд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр албан даалгавар болон хуулиар хүлээсэн хүүхдийн эрхийг хангах үүргээ биелүүлж, идэвх санаачилга гарган ажиллахыг Засаг дарга А.Мөнхбайгальд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ